



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 20 өдөр

Дугаар А/254

Мөрөн сум

Хагас жилийн мал тооллогыг зохион  
байгуулах комисс байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1"в", 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Хагас жилийн мал тооллогыг товлосон хугацаанд аймгийн хэмжээнд зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Тооллогын ажлын бэлтгэлийг сайтар хангуулж, мөрдөгдөж буй заавар журмын дагуу чанартай зохион байгуулж, түүвэрт сонгогдсон өрхийн малыг тооллогод бүрэн хамруулах, тооллогын мэдээллийн үнэн бодит байдлыг хангах, төрийн албан хаагчдын хариуцлагыг өндөржүүлж, гарч буй зөрчил, дутагдлыг газар дээр нь залруулж, холбогдох арга хэмжээг шуурхай зохион байгуулж ажиллахыг тооллогын Комиссын дарга (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

3.Хагас жилийн мал тооллогын ажлыг аргачлал, маягт заавар, арга зүй нэгдсэн удирдлагаар хангаж, тооллогын явцад хяналт тавьж, тооллогын явцын мэдээг тухай бүр танилцуулж ажиллахыг Статистикийн хэлтэс (Б.Базардамбуу)-т даалгасугай.


ДАРГА



П.ЛХАГВАЖАВ



Аймгийн Засаг даргын 2024 оны  
05 дугаар сарын 29-ны өдрийн А/254  
дугаар захирамжийн хавсралт



2024 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН МАЛ ТООЛЛОГЫН АЖЛЫГ  
ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга:

М.Хуягбаатар

(Аймгийн Засаг даргын орлогч)

Комиссын орлогч дарга:

Б.Базардамбуу

(Статистикийн хэлтсийн дарга)

Гишүүд:

Б.Оюунтуяа

(Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн  
хэлтсийн дарга)

Ё.Пүрэвсүрэн

(Онцгой байдлын газрын дарга, хурандаа)

Я.Эрхэмбаяр

(Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)

Б.Өнөрбат

(Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга)

Л.Ариунаа

(Мал эмнэлгийн газрын дарга)

А.Алтанцоож

(Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа)

Нарийн бичгийн дарга:

Т.Алтанцэцэг

(Статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

---oOo---